



# Бөхөнгийн Мэдээ



2005 өвөл: дугаар 2

Бөхөнгийн экологи, хамгааллын асуудлаар 5 хэл дээр хэвлэгдэн гардаг

Зүргийг Владимир Смирин

## Гарчиг

### Сэдэвт өгүүлэлгэ - Хуудас 1

Е.Ж.Милнер Гулланд. Харилцан ойлголцлын баримт бичигт гарын үсэг зурав

### Шинэ мэдээ - Хуудас 2-3

БНХАУ-д болсон CITES-ийн хуралд бөхөнгийн хамгаалах, зөвийн худалдааг зохицуулах асуудлыг хэлэлцлээ

Москвад болсон бөхөнгийн хамгаалах Дарвин болон ИНТАС төслийн багуудын уулзалт ОХУ-д болсон хурлын төлөөлөгчид бөхөнгийн авран хамгаалах яаралтай арга хэмжээ авахыг дахин мэдэгдэв

Америкийн "Fish and Wildlife" байгууллага Оросын бөхөнгийн хамгаалах хичээл зүтгэлийг дэмжье

Бөхөнгийн шинэ үеээн тэтгэгч

Оросод бөхөнгийн тухай шинэ баримттат кино узуулэв

Оросын гаалийн ажилчид Монголоос хууль бусаар хил гаргахыг оролдсон бөхөнгийн

зөрийг илрүүлэв

Хулгайн анчдэг шийтгэв

Казахстан бөхөнгийн хамгаалах шинэ хөтөлбөртэй болов

### Хэвлэлийн тойм – Хуудас 3-4

Чжин Юн "Үстэж буй зүйл хоёр талаас дэлжэлэг авав" China Daily, 5 сарын 31, 2005

Сергей Наумов "Бохон ба хүчинчийн тухийн" Түүчин-ийн, 8 сарын 22, 2005

"Талын хатан"-д шүрслэх хэрэгтэй байна", Казахстанской Правде, 9 сарын 12, 2005

### Эрдэм шинжилгээний өгүүлэгтүүд – Хуудас 5-7

Ю.Арылов. Халимагийн "Зэрлэг амьтны төв"

А. Канг, С. Зениан: Хятадын Гансу мужийн ховор амьтдыг гаршуулан үргүүлэх төв дэх бөхөн

Жон Ван Де Власаккер: Гоөвь-Алтай аймагт явуулсан бөхөнгийн хээрийн судалгаа

### Төслийн эргэн тойронд – Хуудас 7

Төв азиийн экологийн "Эконет" сүлжээний байгууллагадаа

Казахстанд "SOS- бөхөн" төсөл хэрэгжиж байна

Баруун хойд Каспийн мужийн бөхөнгийн радиотелеметрийн судалгаа

### Шинэ нийтийн тойм - Хуудас 8

## Сэдэвт өгүүлэлгэ - Харилцан ойлголцлын баримт бичигт гарын үсэг зурав

Бөхөнгийн хамгаалах түүхэнд чухал үйл явдал боллоо. Кенийн нийслэл Найробид болсон Нуудалзэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенцийн 8-р их хурлын үеэр бөхөнгийн тухай тархсан улсын конвенцийн 8-р их хурлын үеэр бөхөнгийн хамгаалах харилцан ойлголцлын баримт бичиг (ХОББ)-т 2005 оны 11 сарын 25-нд гарын үсэг зурав.

Үг баримт бичигт гарын үсэг зурсан талууд: бөхөнгийн хамгааллагыг үр ашигтай явуулж бөхөнгийн амьдралыг орчны хамгаалах, бөхөнгийн популяци я болон амьдралыг орчны нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, орон нутгийн хамгаалах стратеги болон олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцоог дэмжих, ХОББ-г хэрэгжүүлэх байгууллага бий болгох, Нуудалзэдэг зүйлийг хамгаалах олон улсын конвенцийн ажлын тайлангаа өгч байх зэрэг үйл ажиллагааг тусгасан.

Бөхөнгийн тархсан Орос, Казахстан, Узбекстан, Туркменистан зэрэг улсын 3 юмуу түүнээс олон улс орон ХОББ-т гарын үсэг тохиолдолд уг баримт бичиг хүчин төгөлдөр болно.

Найробид болсон уулзалтанд здгэр ороос зөвхөн Туркменистан гарын үсэг зурав. Үүнээс гадна Монгол, IUCN, WWF, Зэрлэг амьттан, байгаль хамгаалах олон улсын зөвлөл болон CMS-ын төлөөлөгчид энэхүү баримт бичигт гарын үсэг зурлаа. ХОББ-ыг Узбекстан улсын төлөөлөгчид хүлээн зөвшөөрсөн ба Германда болох уулзалтанд албан ёсоор гарын үсэг зурахаар төлөвлөж байна.

Энэ үр дүнд хүрэхийн тулд дараах хувь хүн болон албан байгууллагууд хүнд, хэцүү зам туулан шантраплагийн ажилласан юм. Роб Хепворт, Лайл Гловас (CMS), Холи Дублин (IUCN-SSC), Робин Шарп (IUCN SSC, European sustainable Use Specialist Group), Сю Лайберман (WWF-International), Анна Лущекина, Валерий Неронов (UNESCO-MAB), болон Елина Крейцберг (Төв азиийн байгаль орчны хамгаалах төв) зэрэг хүмүүс болно. Эдгэр болон шаргуу ажилласан бусад хүмүүст бөхөнгийн хамгаалах үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас чин сэтгэлийн талархал илэрхийлэх нь зүйтэй.

Халимагийн Елистаад 2002 онд болсон бөхөнгийн хамгаалах олон улсын хурлаас ХОББ-ийг анх санаачилсан юм. Уг хурлаар CMS-ын бөхөнгийн хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулжээ. Гэвч бөхөнгийн тархсан зарим улс орнууд ХОББ-т гарын үсэг зураагийн улмаас энэхүү асуудал хараахан шийдэгдээгүй л байна. Монгол улс уг баримт бичигт гарын үсэг зурсан нь том амжилт юм. ХОББ-ын бөхөнгийн хамгаалаалд хэрхэн хувь нэмэр оруулах вэ? ХОББ-ын бөхөнгийн хамгаалах олон улсын хэмжээнд нэгдсэн тогтолцоонд шилжүүлэхэд голлох үүрэгтэй ба бөхөнгийн тархсан улс орнууд болон олон улсын териин бус байгууллагууд хамтран хэрхэн юу хийнээс эргэж тайлагнах тал дээр ажиллаж байна. ХОББ нь шинэ боломжийг нээж хөрөнгө оруулагчдыг татах байх гэх найдахад байна. Аливаа тэр засаг бөхөнгийн хамгаалахыг дэмжих байгаа нь CMS илүү үр ашигтай ажиллах нахцэл болно.

Саналуудад үндэслэн иэн тэргүүний хийх зүйлүүдийг гаргасан. Миний бодлого амьдралыг орчны хамгаалах тал дээр голлон анхаарах нь хулгайн антайд тэмцэхээс илүү үр дүнд хүргэж чадахгүй. Бөхөнгийн амьдралыг орчин суулийн хэдэн жилийн байдлаар харьцангуй сайжирсан хэдий ч хулгайн ан хяналтгүй улмаас өнөөг хүртэл газар авсаар байна. Гэхдээ улс орон бүрт энэ нь өөр хэлбэртэй байж болно. ХОББ-т гарын үсэг зурснаар хүмүүсийн бөхөнгийн хамгаалаалд татан ороплуулах боломжуудийг нээж өгөх бөгөөд тэдэнд шахалт үзүүлснээс дээр юм. Мехлийн ирмэгт тулсан бөхөнгийн хамгаалахын тулд бөхөнгийн тархсан улс орнууд ирэздүйд юу хийх нь чухал болохыг сайн тооцож удаан хугацааны үр дүнтэй ажил хийх нь чухал гэдэгт ХОББ итгэл төгс байна.

Э.Ж.Милнер-Гулланд, Лондонийн Эзэн Хааны коллеж. Энэхүү хэвлэлийг INTAS санхүүжүүлж:



**Редакцийн зөвлөл.** Нэгдсэн вант улс Доктор Э.Ж.Милнер-Гулланд, Лондоны зээн хааны коллеж ([e.j.milner-gulland@imperial.ac.uk](mailto:e.j.milner-gulland@imperial.ac.uk)). Хятад: Доктор А.Канг, WCS-ийн Хятад дахь салбар ([ygling@online.sh.cn](mailto:ygling@online.sh.cn)); Казахстан: Профессор А.Бекенов, доктор Лу.А.Грачев, Казахстаны амьттан судлалын хүрээлэн ([teroi@nursat.kz](mailto:teroi@nursat.kz)); Монгол: Доктор Б.Лхагвасүрэн, доктор Л.Амгалан, ШУА-ийн Биологийн хүрээлэн ([ecolab@magicnet.mn](mailto:ecolab@magicnet.mn)), Э.Онон, WWF-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар ([fonon@wwf.mn](mailto:fonon@wwf.mn)); Орос: Профессор Ю.Арылов, Халимагийн зэрлэг амьтны төв ([kalmisaigak@elista.ru](mailto:kalmisaigak@elista.ru)), доктор А.А.Лущекина, Экологи ба эволюцийн хүрээлэн ([mab.ru@relicom.ru](mailto:mab.ru@relicom.ru)); Туркменистан: Доктор Д.Сапармурадов, Туркменистаны целийн амьттан ургамлын хүрээлэн ([sjuma@untuk.org](mailto:sjuma@untuk.org)); Узбекистан: Доктор Е.Быкова, доктор А.Есипов, Узбекистаны амьттан судлалын хүрээлэн ([esip@ktk.uz](mailto:esip@ktk.uz));

**Бөхөнгийн талаархи мэдээ материалы** бээрхүү 5 хэл дээр хүрээлэндээс ([esip@ktk.uz](mailto:esip@ktk.uz)) хаягаар илрэхээс юмуу зөвлөл редакцийн зөвлөлийн гашуудийн хаягдвар хандаж болно. Бий жилд нийт 2 дугаар гарднаа.

**Хэвлэгдсэн сэтгүүлийг** (<http://saigak.biodiversity.ru/publication.html>, [www.iccs.org.uk/saiganews.htm](http://www.iccs.org.uk/saiganews.htm), <http://www.wildlifewarden.net/wcs/minisai/Saiga-Chinese.pdf>) хаягуудаар нэвтрээн орж pdf хэлбэрээр Хятад, Азия, Казак, Монгол, Орос аль хүссэн хэл дээрээ татан аеч болно.

ШУА-ийн Биологийн хүрээлэн туслаачаа үзүүлэв.

## Орон нутгийн болон олон улсын мэдээ



**Хятадад болсон CITES-ын курлаар Бөхөнгийн зөвийн худалдааг зохицуулах, бөхөн хамгаалах талаар хэлэлцэв.**  
Бөхөнгийн зөвийн худалдаа болон хамгааллын талаархи CITES-ын уулзалт 2005 оны 8 сарын 31-нд Бээжин хотод болов. Хятадын Урумчи хотод 2005 оны 8 сарын 22-24 нд болсон "Silk Road CITES Implementation and Enforcement" семинарын зөвлөмжийг энд бас хэлэлцэв. Узалтын туршид янз бүрийн засгийн газрын байгууллагууд (БНХАУ-ын Ойн хороо, Хятадын CITES, Хунс, эмийн ургамлын хороо, Галийн хороо, Эрүүл мэндийн яам, Хятадын уламжлалт анагаах ухааны хороо) болон бусад байгууллагуудын (Хятадын зэрэг байгаль хамгаалах нийгэмлэг, Нэн ховор зүйлийг хамгаалах үндэсний комисс, Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэг - IUCN) төлөөлөгчид оролцож хил дамнасан хууль бус худалдааг зогсоох, хянах, Хятадын уламжлалт эмийн үйлдвэрлэлийг удирдах, засгийн газар бөхөнгийн зөвийн худалдааны зах зээлийг хянах зэрэг олон асуудал хэлэлцлээ. Уулзaltaас гарсан шийдвэрт бөхөнгийн зөвийн худалдаа болон бөхөн хамгааллын талаар дараах саналууд тусгагдлаа. Үүнд:

1. Эмний шинэ технологийг бий болгон бөхөнгийн зөвийг орлуулах түүхий эдийг эрж хайх тал дээр анхаарах
  2. Бөхөнгийн одоогийн статусыг эмч наарт тайлбарлан ойлгуулж, зөвийн хэрэглээг хязгаарлах
  3. Хятадад байгаа нийт бөхөнгийн зөвийн тоог гаргаж маркетингийн системийг бий болгон зөвийн худалдааг хянах
  4. Бөхөнгийн популяцийн гаршуулан уржуулж уламжлалт анагаах ухаанд зөвийн хэрэгцээг хянагаа
- Илүү мэдээл авахыг хүсвэл А.Кантай дараах хаягаар холбоо барина уу [ygling@online.sh.cn](mailto:ygling@online.sh.cn)

### Москвад болсон бөхөн хамгаалах Дарвин болон ИНТАС төслийн багуудын уулзалт

2005 оны 8 сарын 15-16нд Москва хотод Дарвина санаачлага төслийн багуудын уулзалт болон ИНТАС төслийн "Нэн ховор бөхөнгийн нөхөн үржихүүн экологи" төслийн хамтарсан уулзалт болж ирээдүйн хамтын ажиллагааны талаар хэлэлцэв.

Оросын талаас Халимагийн экологийн төвөөс явуулж буй олон нийтийн соёл боловсрол (Р.Медзидов), "Степной" дархан газрын байгаль хамгаалагчдын санаачилсан хулгайн антийн зэрэг явуулж буй ўйл ажиллагаа (А.Хлуднев), Халимагийн зэрэглэг амьттан судалал, хамгаалал төвийн нэг жилийн ажлын үр дүн (CSCWAK) (Ю.Арьлов), "Черные земли" шим мандлын дархан газрын судлаач Г.Эрденовын бөхөнгийн экологийн мониторингийн судалгаа, ОХУ-ын ШУА-ийн Экологи ба эволюцийн хүрээлэн болон CSCWAK-ын хамтарсан хээлтэй бөхөнгийн дааврын судалгаа (В.Вознесенская) зэрэг илтгэлүүдийг хэлэлцэв.



Бөхөнгийн уулзалтад оролцогчид:

Зүүнээс: В.Неропов, А.Хлуднев, Н.Арулова, Л.Арулова, А.Лущейко, А.Бекенов, Р.Медзидов, Т.Айлет, А.Эсипов, Л.Грачев, О.Маллон, Е.Букова

Казакстаны Амьттан судалын хүрээлэнгийн эрдэмтдийн бөхөнгийн популяцийн статус (А.Бекенов, Ю.Грачев) болон энэ жил Устюргад хийсэн бөхөнгийн тэллэлтийн үеийн бөөнгөрлийн судалгааны ажлын талаар илтгэлтавив. Казакстаны үндэсний их сургуулийн судлаач В.Украинскийн Бетпак Далад орон нутгийн иргэдийн бөхөнд хандах хандлагын талаарх судалгааг хэлэлцэв. Устюргын тосгонон иргэдэд жижиг эзэл тусласж олгох нь цаашдаа ямархуу үр дүнгээ өгөх талаар Fauna and Амьттан ба ургамлын олон улсын судлаач Т.Айлет тайлбарлав. Узбекстаны талаас бөхөн өвөлжед Устюргын өмнөд хэсгийн нийгэм болон экологийн нөхцөл байдлын талаар илтгэл тавьсан (Е.Бекова, А.Эсипов), ба уг нутагт бөхөн жилийн турш тогтвортой байршдгийг нотоллоо. Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэгийн (IUCN) мэргэжилтэн Д.Маллон, UNESCO-ын Хүн ба шим мандал хөтөлбөрийн В.Неропов нар бөхөн хамгаалах олон улсын ўйл ажиллагааны тухай мэдээлэл хийсэн. Бид Москва (А.Вознесенская), Элиста (Н.Арьлов), Лондоны эзэн хааны коллеж (А.Кюль)-ын залуу судлаачдын хийж буй судалгааны ажлын талаар ярилцсан. Хурлын төгсөлд үзүүлсэн Александр Мисайлов, Игорь Шпиленко нарын бүтээсэн "Сайга- Карма степей" кино оролцогчдын анхаарлыг гойд татав.

Дарвин болон ИНТАС төслийн хамтарлалтад илүү мэдээл авахыг хүсвэл Е.Ж.Милнер Гулландтай холбоо барина уу. [www.iccs.org.uk](http://www.iccs.org.uk) e.j.milner-gulland@imperial.ac.uk



### Оросд болсон курлаар бөхөн хамгаалах тал дээр яаралтай арга хэмжээ авах тухай хэлэлцэв

2005 оны 6 сарын 3-4 нийт хооронд Москвагийн дүүргийн Королёвод болсон бүх Оросын "ОХУ-д зэрэлгэж амьтдыг хайр гамгүй ашиглаж байгаа асуудал, гарах арга зам" сэдэвт их хурал болов. Хурлын үеэр "Бөхөнг аврах нь" тунхаглал гаргаж Оросын амьтны аймгийн бүрэлдэхүүн болсон нэн ховор бөхөнг хамгаалахын тулд яаралтай арга хэмжээ авах нь тулгамдсан асуудал болсоныг цохон тэмдэглэв.

Москва хотод Оросын ШУА-ын Биологийн төрөл зүйлийг хамгаалах хороо болон Хөхтөн судалын нийгэмлэгийн хамтарсан "Орос дахь бөхөнг гаршуулан үржүүлж, хамгаалах туршлага" сэдэвт семинар 2005 оны 10 сарын 10-нд болж өнгөрөв. Уг хурлаар Оросод бөхөн гаршуулан үржүүлж олж авсан туршлагыг нэгтгэн дүгнэж, туршлага солилцон, цаашид гаршуулж буй нөхцөлд бөхөн хамгаалах стратегийг боловсруулав.

Дээрхи 2 олон улсын хурлын талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл <http://www.saigak.biodiversity.ru/> -ийг үзнэ үү!

### АНУ-ын "Загас болон Зэрлэг амьтны алба" Оросын бөхөн хамгаалах ўйл ажиллагааг дэмжих байна

2005 оны 6 сарын 22-нд АНУ-ын "Загас болон Зэрлэг амьтны алба" нийт 23.400 ам.долларын санхүүжилт хийснээс мэдэгдсэн бөгөөд үүнд: "Черные земли" шим мандлын дархан газрын байгаль хамгаалагчдыг радио станц болон бусад тоног төхөөрөмжөөр хангах, нөөц газрын эргэн тойронтой харуулын цэгийг байгуулах, Халимагт байрлах Яшкул бөхөн гаршуулан үржүүлэх төв дэх зочдыг утган авах байрыг барих зэрэг болно.

[http://usembassy.ru/embassy/releaser.php?record\\_id=48](http://usembassy.ru/embassy/releaser.php?record_id=48) -ийг үз!



Яшкул бөхөн үржүүлгийн төвийн зочид хүхэрлэг авах шинэ төв.  
Гэрэл зурагийн: Анна Лущейко

### Бөхөнгийн шинэ ивээн тэтгэгч

Халимагт газрын тос болон байгалийн хий олборлодог "ИТЕРА" компани үндэсний болон олон улсын бөхөн хамгаалах байгуулагуудтай хамтран ажиллахаар нэгдэв. Уг компани Халимагийн засгийн газраас бөхөн гаршуулан үржүүлэхэд зориулж байгуулсан 800 га газрын тохиолтанд санхүүжилт олгов. Энэхүү компанийн экологийн ўйл ажиллагаа нэн тэрүүний ажил бол Халимагийн бөхөнгийн популяцийг хамгаалах явдал мөн гэж компанийн зүгээс мэдэгдэв.

<http://www.tver.org/archive/archive.htm> - ийг үз.

### Оросын бөхөнгийн тухай шинэ баримтат кино үзүүлэв

Оросын кино зохион бүтээгч Александр Мисайлов, Игорь Шипленок нарын бүтээсэн "Талын карма-Бөхөн" сэдэвт баримтат кино энэ жил гарлаа. Бөхөнгийн тухай бол тал хээртэй салшгүй холбоотой. Өнгөрсөн зууны 2-р хагасаас бөхөнг олноор нь агнах, онгон байгалийг хэт ашиглах зэрэг аюул занал учирж эхлэсэн.

Уг кинонд хууль бус анчид, байгаль хамгаалагч, байцаагч, орон нутгийн хүмүүсийн яриа, түүхэн баримтат зураг, яруу найраг зэрэг оржээ. Хүний шунал, ашиг сонирхолтой салшгүй холбоотой энэ амьтны тухай сэтгэл хөдөлгөсөн киноны ўйл явдал нь үзүүчдийн сэтгэлд нэгийг бодогдуулна. Киног Халимагийн Зэрлэг Амьтан хамгаалахын төвийн төлөөлөгчдөд эхэлж үзүүлсний дараа, олон нийтийн телевизээр гаргасан.

<http://www.biiversity.ru/programs/saigak/news/061005.html> - ийг үз.

### Оросын гаалийн ажилтнууд Монгол руу хууль бусаар бөхөнгийн зөвийг хил гаргахыг завдаж байсныг илрүүлэв

Оросын Наушкин гаалийн ажилтнууд 2005 оны 8 сарын 12-нд Монгол руу 11 орчим килограммийн нийт 67 ширхэг бөхөнгийн зөвийг хууль бусаар нэвтрүүлэх гэж байсныг илрүүлэв. Эдгээр бөхөнгийн зөвийг Монголын иргэнээс хураан авч улсын орлого болгов. ОХУ-ын хил гаалиар хууль бусаар бараа гаргасан тохиолдолд хуулийн дагуу хураан авсан барааны үнийг 3 нугалиж төлүүлдэг байна.

[http://www.amic.ru/news/?news\\_id=687](http://www.amic.ru/news/?news_id=687) - ийг үз.

### Хулгайн анчдыг шийтгэв

Шалкарски мужийн Босой тосгоны ойролцоогоос хууль бусаар бөхөн агнасан хоёр хулгайн анчдыг 2005 оны 11 сард Актюбинск районы Дотоод Явдлын Яамны ажилтан болон ойн аж ахуйн ажилтнууд хамтран илрүүлэв. Бөхөн буудаж агнасан тэдгээр хулгайн анчид 600 мяняга орчим тэнгетгийн (ойролцоогоор 4.4 мяняган ам.доллар) хохирол учруулжээ. Казахстан улсын зуругийн хуулийн 288 тоот хуулийг үндэслэн хулгайн анчдыг тус нутгаас гадаш гарахыг хориглон зуругийн хэрэг үүсгэжээ. Казакстан улс оны эхнээс нийт 7 хулгайн ангийн тохиолдлыг илрүүлэв. Хулгайн ан суулийн жилүүдэд бүлэглэлийн шинж чанартай болж байна. Шалкарски тосгоны орон нутгийн шүүх Узбекстан улсын 2 иргэнд 2005 оны 6 сард шийтгэл ноогдуулав. Учир нь тэд Казакстан улсын Устюртын талд хулгайн ан хийсэн байна. Хууль зөрчин нийт 9 бөхөн агнасан эдгээр хулгайн анчдыг 1.4 сая тэнг (ойролцоогоор 10.4 мяняган ам.доллар) -ээр тортон, 2 жилийн хорих ялаар шийтгэв. <http://www.earthwire.org/kz/account.cfm> - ийг үз.



Байгаль хамгаалагчдын баг,  
Гэрэл зурагийг: Жээн Франкайс Лагрот

### Казакстанд бөхөн хамгаалах шинэ хөтөлбөр батлагдав

Казакстаны засгийн газрын 2005 оны 3 сарын 25-ны 267 тоот шийдвэрээр "2005-2007 онд ховор ба нэн ховор амьтад болон бөхөн хамгаалах хөтөлбөр"-ийг батлав. Энэхүү хөтөлбөрийг Казакстаны БШУ-ы яамны харьяа Амьтан судлалын хүрээлэн болон ХАА-н яамны Ой, агуулрын улсын хорооны мэргэжилтнүүд боловсруулсан. Сайдын хэлснээр хөтөлбөрийн хэрэгжилтэнд 180 сая тенге (ойролцоогоор 1.3 сая ам.доллар)-ийг улсын төсвээс зарцуулахаар болов.

## Хэвлэлийн тойм

Хятад: Өдрийн хэвлэл, 2005 оны 5 сарын 31

### Устаж буй зүйл хоёр талаас дэмжлэг авч байна

Хятадын уламжлалт анагаах ухааны эм зүйч нар болон байгаль хамгаалалын мэргэжилтнүүд хамтран үзэл болдоо солилцож, бөхөн хамгаалах арга замуудыг хэлэлцэв. Уулзалтын үр дүнд тоо толгой нь эрчимтэй хорогдож буй бөхөнгийн популяцийн дан ганц экологийн нэхцэл байдал тедийгүй ХУАУ (Хятадын уламжлалт анагаах ухаан)-ы тогтвортой хөгжлийн тал дээр хамтран ажиллахаар тохиолцлов. Хятадын ХУАУ-ы холбооны тэргүүн Жианг Факуй хэлэхдээ: "Бид ХУАУ-ы бөхөнгийн зөвийн хэрэглээг хянаж эхлэх хэрэгтэй, зохисгүй хэрэглээ нь бөхөнг устахад хүргэнэ" гэжээ.

Сүүлийн жилүүдэд Хятадын Хүнс болон Эм зүйн яамны зөвшөөрлөөр ХУАУ-ас гаргасан шинэ бэлдмэлжийг цусны даралт ихсэх, ханиад томуу зэрэг өвчнийг анагаахад хэрэглэх болсон бөгөөд энэ бэлдмэлжийн гол түүхий эд бөхөнгийн зөврүү. "Бөхөнгийн зөвийг ашиглан иймэрхүү нийтлэг өвчнийг анагаах эм үйлдвэрлэх юм бол бөхөнгийн зөвийг хэрэглээг эрс ёсч устах аюулда хүрнэ" гэж ХУАУ-ын Хятадын академийн Онолын хүрээлэнгийн профессор Чоу Чаофеен хэлэв. "Бөхөнгийн зөвийг зөвхөн хунд өвчнийг анагаах эм бэлдмэлж хэрэглэх нь зүйтэй" гэж тэр зөвлөөд бусад хэрэглээг хатуу хянах хэрэгтэй" гэв. Байгаль хамгаалагч, судлаач Али Канг ховордоогүй зүйл болон синтетик орлуулагчийг ашиглан бөхөнгийн зөвийг орлуулах хэрэгтэй гэж санал болгов. Төв Азийн бөхөнгийн популяцийн тоо толгой хурдацтай багасч буй гол хүчин зүйл нь нутгийн иргэд гэр бүлээ тэжээхийн тулд бөхөнг хулгайгаар хэт олноор нь агнах явдал юм. Хулгайн анчид зөврэнд нь болж бөхөнгийн ооныг агнадаг бөгөөд нэг кг зөвийг 100 ам.доллараар зардаг. Сүүлийн жилүүдэд Хятадын хил гаалиар бөхөнгийн зөврүү хууль бусаар гаргахыг завдсан нийт 15 тохиолдлыг илрүүлэн Хятадын хэвлэл, мэдээллээр цацжээ. ХУАУ-ы эмийн жоронд 2000 жилийн тэртээгээс бөхөнгийн зөвийг ашигласаар иржээ. Туруутан амьтдын дотроос бөхөнгийн зөврүү анагаах чадвараар хамгийн сайн гэж тооцогдоор ирсан байна. ХУАУ-ы энэ байр сууринаас үүдэн шинжээчид, судлаачид бөхөн мөхлийн ирмэгт тулсыг анхааруулсаар байна. Бөхөнгийн зөвийг орлуулах бүтээгдэхүүний олох эсвэл нийллэг аргаар гаргаж авах тал дээр ХУАУ-ы мэргэжилтнүүд санаа зовник байна. Судлаачид ямааны зөврүү зарим талаар бөхөнгийн зөвртэй ижил нэйрлагатай бөгөөд үүнийг орлуулан анагаах ухаанд ашиглах болохыг 2001 онд тогтоожээ. Эмийн хэрэгцээг хангахын тулд Казакстан, Орос улсуудаас бөхөн авчирч гаршуулан үржүүлэх нь устаж буй бөхөнгийн популяцийг авран хамгаалах өөр арга зам юм.

Зи Ёонг

Бүрэн эхээр нь:

[http://www.chinadaily.com.cn/english/doc/2005-05/31/content\\_447068.htm](http://www.chinadaily.com.cn/english/doc/2005-05/31/content_447068.htm) –ээс үзэн үү!

Узбекистан: Tribune-uz, 2005 оны 8 сарын 22.

### Хүн ба бөхөнгийн тухай

Цус шингэсэн хөрс нь нядалгааны газрыг санагдуулна. Шинэ жил болохоос хоёр долоо хоногийн өмнөхөн ашиг хонжоо хайгчид бөхөнг алж устган эвэр, махыг нь авсан нь энэ. Кунград-Бейнеу төмөр замын ойролцоо хэдэн зуун бөхөн тааламжтай газар нутаг хайн нүүдэллэж ирээд бүгд алуулжээ. Хэн ч хеерхий амьтныг хамгаалахыг оролдсонгуй. Хамгаалах хүн ч ойр хавьд байсангуй. Хулгайн ан үүний шалтгаан болсон. Хятад, Сингапур, Малайзийн зах зээлд бие гүйцэн бөхөнгийн эвэр 1 кг-ны 30-70 амдолларын үнэ хурч эрэлт хэрэгцээ маш их байна. Амьтнан судлаачдын сэтгэл зовник буй асуудал бол бөхөнгийн популяцийн 3 болон түүнээс дээш насын оноо агнагдж дуссан ба анчид суулийн үед заплуу оноо агнаж байна. Өмнө нь заплуу бөхөнг агнадаггүй байсан ба энэ нь эдийн засгийн хувьд ач холбогдол багатай байжээ. Бөхөнгийн эврийн үнэ 10 дахин өссөний улмаас олон тооны зуучлагчид бөхөнгийн эврийг Хятад руу гаргаж байна. Саяхан болтол анчид бөхөнгийн эвэр авах гэж агнаж махыг хаядаг байжээ. Гэвч суулийн үед амьдрал хүнд болсны улмаас бөхөнгийн махын хүнсэнд хөргөлж болсон. Устюорт даяар бөхөнгийн махны үнэ килограмм нь 800-1500 УЗС (Узбек сум) буюу ойролцоогоор 0.8-1 амдолларын ханштай байна. Зах зээлд махны үнэ тогтвортой байгаа нь хулгайн ан гарсаар байх боломжийг олгож байна. “Бид өөрийн нутагтаа бөхөнг маш сайн хамгаалж нер их хөдөлмөрлөж байхад Узбекистан нутагт бөхөн нүүдэллэн очиход тэд маш ихээр агнадаг” гэж казахчуудын гомдоллож байгаа нь үнэн юм. Устюортын бөхөнгийн популяцийн гуравны нэг нь манай нутагт өвөлждөг юм.

Судалгаагаар зарим сонирхолтой зүйлийг илрүүлжээ. Устюортад дэнгэж 30 жилийн өмнө газар газраас хүмүүс ирж суурьшсан байна. Устюорт бол бөхөнгийн олон зуун жил амьдарсаар ирсэн газар нутаг гэдгийг тэдэнд хэлэх нэг ч хүн байгаагүй. ЗХҮ-ын үед тэдээр хүмүүс өөр өөрсдийн соёл, заншлыг авчирж хөгжсөн бөгөөд байгалийн баялгийг ашиглах, өөрсдийгээ байгалийн салшгүй хэсэг гэдгийг ухамсарлах ойлголт маш ялгаатай байжээ.

Гэхдээ асуудлыг шийдвэрж болно. Бодит сайхан жишээ нь Казакстан, ОХУ хоёр юм. Бөхөнг хамгаалах олон улсын төслийд хэрэгжиж байна. Эдгээрт Узбекистан ч оролцож байна. Асуудлыг нааштай шийдвэр сунирхолтой хүмүүс ч байна. Заавар, зөвлөмжийг өнөөдөр амьдралд хэрэгжүүлэх цаг болсон. Үүний тулд олон нийт, засгийн газрын дэмжлэг хэрэгтэй. Гэтэл амьдрал дээр байдал ямар байна вэ?

Ихэнхи хүмүүст хулгайн ан амь зуух арга зам нь болсон. Негеэ талаар бөхөнгийн хэт агналтанд засгийн газар хяналт тавьдаггүйгээс орон нутгийн хүмүүс эврийн худалдаагаар ашиг олох гэж улайрч байна. Хулгайн анчдын бүлэглэлүүд Устюортын тосгон болгонд байна. Каракалпак тосгонд 100 гаруй мотоциклтой хүмүүс амьдардаг.

Кунград-Бейнеу төмөр замын дагуу бөхөнгийн нүүдлийн зам дайрч өнгөрдөг ба нутгийн зүүн хэсэг тэр чигээрээ зэвэргүй толгой бүхий араг ясаар дүүрсэн байна. Бөхөнгийн хувхайран яснууд үлэг гүрвэлийн оршуулгын газрыг санагдуулна. Тосгоны оршин суугчид тэдний амьдралын салшгүй нэг хэсэг болсон тэр сайхан амьтныг устаж байна гэдгийг үл ухамсарлан бүтэн жилийн турш бөхөнг агнадаг. Бөхөнгийн жижиг сүргүүд оргонох газар хайж Устюортын тал хээрээр сандралдан гүйлдэж байна.

**Сергей Наумов.** Бүрэн эхээр нь [www.tribune-uz.info](http://www.tribune-uz.info) –ээс үз.



Устюорт: эврий нь авсан гавлын яс  
Гэрэл зурагийг: Александр Эспилов.

**Казахстан:** Казахстанская правда, 2005 оны 9 сарын 12

### “Талын хатан”-д тусламж хэрэгтэй байна

Хүрээлэн буй орчин түүн дотроо онгон байгаль хамгаалал, түүний чиг хандлага нь нэн тэргүүний зорилт бөгөөд үндэсний хэмжээнд хэлэлцэгдэж байна. “Казахстаны байгаль хамгаалал, дархан газрын сангийн хөгжлийн хэтийн төлөв ба асуудлууд” сэдвээр Мажилис тойргийн депутат Раян Шаекин илтгэл тавилаа. Бөхөнгийн популяцийг нөхөн сэргээхэд чиглэгдсэн үйл ажиллагаа нь амжилтанд хүрсэн гэж депутат үзж байна. Үүнд: нэгдүгээрт, Казахстаны бөхөнгийн популяцийн тоо толгойн ердийн өсөлтэнд нелеөөлж буй серөг нелеөөг багасгасан. Бөхөнгийн популяцийг нөхөн сэргээхэд шаардагах хөрөнгө мөнгийг улсын төсвөөс жил бүр гаргасан. Нийт 686 сая тенге (5 сая орчим амдоллар)-ийг ховор болон нэн ховор туруутан амьтад болон бөхөн хамгаалах хөтөлбөрийн хэрэгжилтэнд 2005-2007 онд зориулж гаргахаар төлөвлөсөн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд шинэ ТХГН байгуулах, хилийн хяналтын системийг сайжруулж 24 цагийн эргүүлтэй болгох болон бөхөнгийн популяцийг хамгаалах бусад арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх зэрэг ажлыг хийхээр төлөвлөсөн. Бөхөнгийн нүүдлийн замын дагуу болон тархац нутагт нь амьдардаг хүмүүсдүү сургалт, сурталчилгаа явуулсан нь үр дүнгээ өглөө. Нутгийн иргэдийн амьжиргаа дээшилснийг тэмдэглэх нь зүйтэй. Өнөө үед тосгоны оршин суугчид бөхөнгийн махыг өвлийн хүнсэнд нөөцлөхөө больсон нь тэдгээрин ихэнхи нь малтай болсонтой холбоотой аж. Сүүлийн жилүүдэд бөхөнгийн эврийн хил дамнасан хууль бүсийн нийтийн тулд хил гаалийн хяналт чанаржин сайжирсантай мөн холбоотой. Гэвч энэ арга хэмжээ нь асуудлын нэгээхэн хэсэгийг шийдсэн бөгөөд бөхөнгийн тоо толгой санасан хэмжээнд хуртлээ өсөхгүй байна. Парламентын хурлын шийдэрүүдийг үндэслэн олон санал, зөвлөмжийг засгийн газарт өргөн барьсан. Тухайлбал, Караганда музкийн Сарсын голын баруун сав газрын 6000 км<sup>2</sup> нутгийг БНГ болгох, мөн ховордож буй бөхөнг Казахстаны улаан номонд оруулах нь зүйтэй гэж үзсэн. Гэвч нэг жил гаруй хугацаа өнгөрсөн ч бодит өөрчлөлт гарсангүй. Орон нутгийн удирдлагууд байгаль орчны асуудалт анхааралтагаа тавьж буйгаас болж БНГ байгуулах асуудал шийдэгдээгүй л байна. Бөхөнгийн популяцийг нөхөн сэргээхэд чиглэгдсэн засгийн газрын үйл ажлаагаа санхүүгийн байдлаас шууд хамааралтай. Улсын төсвөөс хөтөлбөрийн хэрэгжилтэнд зориулан гаргасантай тэнцэхүйц хэмжээний хөрөнгийг орон нутгийн төсвөөс гаргахыг зөвшөөрсөн. Гэсэн хэдий ч орон нутгийн удирдлагууд үүнийг хайрхахгүй байна. Р.Шаекин депутатын үзэж байгаагаар бөхөнгийн популяцийн тоо толгой нэмэгдүүлэхэд засгийн газрын төдийгүй олон нийтийн байгууллага, хөдөлгөөний үйл ажиллагаа чухал байна. Залуу үеийнхэнд зориулсан боловсролын болон ухамсрын арга хэмжээнүүд зохион байгуулах шаардлагатай. Цаашилбал бөхөнг гаршуулан үржүүлэн, нүүдлийн болон төллөдөг газар нутгийг нь хамарсан ТХНГ-ын сүлжээг өргөтгэж, популяцийн мониторингийн судалгаа хийх хэрэгтэй. Туркменистан болон Узбекистантай засгийн газрын хоорондох харилцааг сайжруулах нь эдгээр улсуудын нутгийг дамжин өвөлждөг бөхөнгийн популяцийг хамгаалах, тоо толгой нь нөхөн сэргээхэд чухал ач холбогдолтой. Одоогийн байдлаар эдгээр олон ажлын зөвхөн эхлэлийг тавьсан ба их хэмжээгээр гарч буй хулгайн ан аажмаар буурч байна. Гэсэн хэдий ч “Талын хатан”-д өнөөг хүртэл тусламж хэрэгтэй байна. Хөтөлбөрийн үр дүнг 2007 онд дүгнэнэ.

Бүрэн эхээр нь <http://www.earthwire.org/cache.cfm?aid=96952> –ээс үзэн үү!

## Эрдэм шинжилгээний өгүүллэгүүд

**Бүгд найрамдах Халимаг улсын зэрлэг амьтдын төв**

Юрий Н. Арылов

Оросын Бүгд найрамдах Халимаг улсын зэрлэг амьтдын төвийн захирал

Бөхөнгийн генетик олон янз байдлыг хадгалан үлдээх, зүүн хойд Каспин мушкин бөхөнгийн популяцийг авран хамгаалах зорилготойгоор Зэрлэг амьтдын төвийг 2000 онд Халимагийн ерөнхийлөгчийн зарлигаар байгуулжээ.

Төвийг байгуулсан нь бөхөн хамгаалах олон улсын курлаас (Элиста, 2002 оны 5 сар) гарсан зөвлөмжийг урьдчилан харсан мэт болсон. Төвийн үндсэн зорилго нь бөхөнг үргүүлэлн зэрлэг байгальд нь буцаан тавих, судалгаа шинжилгээний ажил хийх, олон нийтэд сурталчлах явдал юм Яшкул дуурэг дахь зэрлэг амьтдын төвд байгалийн нөхцөлд бөхөнг хаших бололцоотой 800 га газар нутгийг Халимагийн засгийн газар олгосон. Хашаа бусад жижиг байгууламж нь Мюнхен ба Денверийн амьтан судалалын нийгмэлэг, Зохимжит нэгдлийн хүрээлэн (АНУ), Том өвсөн тэжээлтэн амьтдын сан (Нидерланд). Загас ба зэрлэг амьтны алба (АНУ), Амьтны хүрээлэн тэтгэх сан (Нидерланд). Ховор зүйл-хүмүүсийн итгэл (НВУ), ТНТ-Экспресс (Орос) болон газрын тос-хийн компани "TERA" зэрэг байгууллага, засгийн газрын дэмжлэгээр бий болсон.

Одоогоор 62 га талбайтай хашаанд 60 гаруй бөхөн байршил байна. Зэрлэг амьтдын төв нь бөхөнгийн генетик болон дааврын өөрчлөлтийн судалгаа явуулж, олон улсын болон орон нутгийн хурал, семинарыг зохион байгуулж байна. Бид бөхөнгийн бүх наасны бодгаль, хөхүүл янзаганы зохимжит тэжээлийн хувийг тооцож олсон нь төлийн хорогдлийг багасгах чухал холбогдолтой болсон. Бидэнд бөхөнг хеделгээнгүй болгох, бөхөнгийн үргүүлэлгээ хийх зэрэг бодит практик туршлага бий. Төлийн хорогдол, гэмтэж бартэх үйл явц одоо багассан.

**Зураг 1. Бөхөнгийн хашаанд төрхөхөөс өмнө нэмэлт эрдэс тэжээл витамин, концентрациар тэжээж буй байдал.** Зураг. Анна Лущекина



Хашаанд байгаа бөхөнд теплехөөс өмнө амин дэм, эрдэстэй номжийн тэжээлгээдэг

Гэрэл зургийг: Анна Лущекина

**Зураг 2. Халимагийн улсын их сургуулийн Биологийн салбарын оюутнууд бөхөнгийн орооны үеийн ажиглалт хийж буй нь.** Зураг. Анна Лущекина

**Зураг 3. Яшкулын хэл зүйн сургуулийн сургачид бөхөн үргүүлэлтэй төвийн андууд юм.**

Зураг. Анна Лущекина

Төв нь ЮНЕСКО-гийн Хүн ба шим мандал хөтөлбөрийн Оросын хороо, Оросын хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн Үхэр үргүүлгийн судалгааны хүрээлэн, Оросын ШУА-ийн Экологи, эволюцийн хүрээлэн зэрэг бусад олон байгууллагатай амжилттай хамтран ажиллаж байна. Биохими, серологи, бактериологи, гельминтологийн судалгаанууд эхэлж байна. Бөхөнгийн үр хөвөрлийн банкыг бий болгон Оросын хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн мал аж ахуйн хүрээлэнд хадгалаад байна. Тус төвтэй хамтран ажиллагч Дарвины санаачлага төслийн боловсролд зориулсан тэтгэлгийг Халимагийн улсын их сургуулийн Биологи, Хөдөө аж ахуйн салбар, Хөдөө аж ахуйн коллежи болон бусад боловсролын салбарын оюутнуудад судалгааны чиглэлээр олгосон.



Халимагийн Их Сургуулийн Биологийн факультэтийн оюутнууд ажиллант хийж байгаа нь

Гэрэл зургийг: Анна Лущекина

Бөхөнгийн экологийн судалгаанаас гадна тус төвийн эрдэм шинжилгээний ажилтангууд "Чёрные земли" шим мандлын ноец газрын хөгжлийг дэмжих, агросистемийн бутзэмжийг всгэх зорилго бүхий судалгаанд хамрагдаж байна. ЮНЕСКО-ийн Москвагийн товчооны санхүүгийн тусламжаар, Бүх Оросын гидротехник, усжуулалтын хүрээлэнтэй хамтран анхны туршилтын шатыг 2004 онд тус төвд эхлүүлсэн. Энэхүү "Бэлчээрийн бутзэмжийг дээшшуулэх, экологийн нэхөн сэргээлт хийх арга зүйн хөгжлийг" төслийн үр дүн орон нутгийн захиргааны сонирхолтыг татсан ба зэрлэг болон гэрний амьтдын тэжээлд оролцох ургамлын үрийг хадгалах боломжийг эрж хийх, ирээдүйд бий болгох боломж нээгдэж байна. Зэрлэг болон гэрний малын бэлчээр сайжруулах нь орон нутгийн амжирааны түвшинг дээшшуулэх болон бөхөнг хамгаалах ажлын өөр нэгэн арга зам болно. Төв нь бөхөнгийн хамгаалал, судалгааны олон улсын тэргүүлэх зэргийн хамтран ажиллагч бөгөөд Английн Дарвины санаачлага, ИНТАС, ПТИС зэрэг байгууллагуудын дэмжлэгтэй төсөл хэрэгжүүлдэг.

Европын бөхөнгийн популяцийг хамгаалах ажлын амжилт нь нийгмийн бүх давхаргын хүмүүсийн идэвхитэй оролцоогоор бий болно. Тиймээс Орос болон бусад улсад явагдаж буй бөхөнгийн хамгаалал, төлөвлөгөө, хэрэглээ, популяцийн хөдлөл зүй, орших газар, бөхөнгийн түүх зэргийг сурч мэдэж болох төвийг бий болгох нь чухал байна. Зэрлэг амьтдын төв нь Бүгд найрамдах Халимаг улсад мэдээлэл сурталчилгаа явуулж буй нэг төвийн жишээ юм. Өсөн нэмэгдэж буй үзүүг, сонирхогчдын тоог нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн удирдлагатай ойрхон холбоотой байх хэрэгтэй, бид том өвсөн тэжээлтэн амьтдын сан, Америкийн загас болон зэрлэг амьтдын алба зэрэг байгууллагуудын тусламжтайгаар үзүүг, сонирхогчийн төвийн барилгыг барьж нэгэнт дуусгалаа. Энэхүү төв нь монгол гэртэй тестэй Халимаг гэр бөгөөд мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх, хээр талын экосистемд бөхөнгийн үүрэг, орон нутгийн иргэдийн амьжирааны түвшинг дээшшуулэх талаарх бүхий л хэрэгцээт мэдээлэл тавьсан байдаг. Хууль бус ан, байгаль орчны хууль зөрчилт, Халимагийн түүх, зэрлэг амьтдын төвийн байгуулалтын талаарх мэдээлэл тус төвд тавигдсан байдаг. Сонирхогчийн төв фото зураг агуулсан хөдөлгөөнт үзмэр, ном зохиол, ханын сонин, Халимагын алслагдсан бэлгүү нутгийн тухай видео бичээг үзүүлэх бараж хэрэгслээр бурэн хангагдана.

Илүү мэдээлэл авахыг хүсвэл Бүгд найрамдах Халимаг улсын Зэрлэг амьтдын төвийн захирал Юрий Арыловтой холбогдоно уу [kalmsaigak@elista.ru](mailto:kalmsaigak@elista.ru).



Үргүүлах төвийн найзууд: Яшкул сургуулийн найзууд

Гэрэл зургийг: Анна Лущекина

## Хятадыг Гансу мужийн ховор зүйлийг үргүүлэх төвийн бөхөн гөрөөс

Али Канг<sup>1</sup>, Сю Тзенянь<sup>2</sup>

1-Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газар

2-Хятадын Гансу мужийн ховор зүйлийг үргүүлэх төв



Гансу мужийн үргүүлэх төв 1987 онд байгуулагдсан, хойд Цилиан уул, Тэнгэр цэлийн баруун урд төгслэлийн хооронд 37.90N, 102.90E солбицолд оршдог (газрын зураг дээр сумаар заасан байгаа). Далайн түвшинээс 1766 метр өргөгдсөн, элсэрхэг, цэлийн шинжтэй. Эх газрын эрэс тэрс, хуурай уур амьсгалтай. Бус нутаг Graminae, Chenopodiaceae, Pallionaceae овгийн (Лию 1993, 1996a, 1996b) 116 зүйлийн урамлан бүлгэмдэлтэй. Төвийн газар нутгийн хэмжээ 170.000 га. Гансу мужийн Линькоу хотын захираа, Гансу мужийн ойн товчоо үйл ажиллагааг эрхлэн явуулдаг, 49 ажилтантай. Сургалт, сурталчилгаа явуулах зорилгоор 700 метр квадрат талбай бүхий төвийг байгуулжээ. Тус төвд 45 зүйлийн 380 бодгаль байна. Бөхөн, тахь адлуу, хавтгай тэмээ, хулан адлуу, түнд хулан адлуу, сармагчин, такин, цагаан хамарт буга, толбот буга, халиун буга, түнд цагаан зээр, хөх аргал хонь зэрэг зүйлүүд зонхишир. Амьтан хашиг топ нь ойролцоогоор 5.850 метр квадрат хэмжээтэй. БНХАУ-ын уламжлалт анаагах ухааны улсын хороо, улсын ойн хороо бөхөнгийн популяцийг сэргээн нутагшуулах төслийг явуулж байна. Анх АНУ-ын Сан Диего, Германы Берлини амьтын хүрээлэнгээс 1998 онд 12 бодгаль авчран үйл ажиллагаагаа эхэлсэн.

Бөхөн үргүүлэх судалгааг 1988-1993, 2001-2003 онуудад хийжээ. Төллөлт, орооны үеийн зан тэрх, өндөн эс боловсрох идэвхитэй байх үеийн зан тэрхийн ажиглалт зэргийн хүрээнд судалгааг явуулжээ (Тан нар 1994a, 1994b, 1994e, Канг нар 2001). Энэ уед бөхөнгийн 23x30 метр хэмжээтэй тороон хашаанд хашиж хамгаалагч нь тэжээж байсан. Тороон хашааг 1992 онд сунгаж 27 га болгосноор амьтад сүл чөлөөтэй бэлчих болсон. 2004 оны өвлийн тоо толгой 29 бодгальд хүрсэн. 2005 онд 16 янзагаа төрж сүргийн хэмжээ 40 гаруй бодгаль болсон.

Тус төвөөс дараагийн жилүүдэд бөхөнгийн талаар авч хэрэгжүүлэх төлөвлөгөөнд сургийн хэмжээг нэмэгдүүлэх, генетик мониторинг, нөхөн үржихүүн судалгааг хийжээр болжээ. Судалгаа шинжилгээ, хамгааллын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, мэдээлэл солилцох, материал-техникийн баазаа бэхжүүлэхэд анхаарна. Илүү мэдээлэл авахыг хүсвэл Али Кангтай холбоо барин уу. [ygling@online.sh.cn](mailto:ygling@online.sh.cn)



Зураг: Мөргөлдөж буйд хэржин. Гансу мужийн цэрэгцүүлгийн төв. Зүргийг Али Канг.

## Говь-Алтай аймагт хийсэн бөхөнгийн хээрийн судалгаа

Жоп ван де Власаккер  
Том өвсөн тэжээлтэн амьтдын сан



Монгол бөхөн нь (*Saiga tatarica mongolica*) зөвхөн Монголд тархсан эндемик, дэд зүйл. Өнгөрсөн зуунд монгол бөхөнгийн зээмшил нутаг даруй 80 хувиар буурчээ. Одоогоор зөвхөн баруун монголд Говь-Алтай, Ховд аймгийн нутагт байна. Монгол бөхөнд тулгарч буй үндсэн аюул нь мах, зөвийг ашиглахын зорилгоор хууль бусаар агнах, байгаль цаг уурын хунд нөхцөл, хүний нелее, малтай бэлчээр усаар өрсөлдэх, зээмшил нутгийн хумигдлагал зэрэг юм. Хамгийн таяатай бэлчээр усиг ашиглахын тулд малтай өрсөлджээ вөрт тохиромжгүй нутгийг ашиглаж байна. Урт хугацааны ган гачигийн нелееөөр бэлчээр доройтох бөхөн тэжээлэйн гачигдадл орж зарим өвлийн өвлийн нийтийн төслийг хэрэгжүүлсэн.

Эдгээр аюул заналыг арилгахын тулд дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Том өвсөн тэжээлтэн амьтдын сангийн дэмжлэгтэйгээр 1998-2001 онд "Монгол бөхөнгийн хамгаалал" төслийг хэрэгжүүлсэн.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар бөхөнгийн зээмшил нутгийн хэмжээнд өвлийн хадлан бэлтгэл, чадварлаг бөхөн хамгаалагчдын сүлжээ гэсэн 2 үндсэн дэмжлэгийг орон нутгийн зүгээс (сум) аваад байна. Одоогоор 9 бөхөн хамгаалагч ажилладаг. Нэг байгаль хамгаалагчид хэдийгээр 120-140 мянян га газар ноогддог ч хулгайн ан бараг зогссон. Дээрх дэмжлэгийн хамт дулаан өвлийн нелееөөр 2000 онд бөхөнгийн популяци 5300 хүртэл өсчээ. Харамсалттай нь судалгаагаар бөхөнгийн популяци 2003 онд 1020, 2004 онд зөвхөн 750 бодгаль болтлоо буурсан байна. Одоогоор популяцийн хэмжээг 1550 бодгаль гэж үнлэж үүнээс 1500 бодгальтай, 50 бодгальтай хөөр популяци бий гэж үзжээ байна. Бидний хээрийн судалгааны явцад 150 орчим бөхөн үзэгдсэн бөгөөд 1-2 км-ийн зайнаас үргэн зугтаж хүнээс айх зан тэрх илүү давамгайлсан байлаа.



Зураг: Жоп ван де Власаккер, Л.Түүвэр нар бөхөнгийн судалгааны багийн хамт (дээд талд). Зүгтаж буйд бөхөнгийн шаргагчин (доод талд). Зүргийг Жоп ван де Власаккер/Плаксакер/Натур Консултантц

Бөхөнгийн популяцийн байдал өвлийн бэлчээрээс хамаарч, гэрийн малтай өрсөлдөх байдлаар хязгаарлагдаж байна. Иймд бөхөнгийн эзэмшил нутагт гэрийн мал бэлчээхийг багасгах хэрэгтэй. Хулгайн ан мөн л асуудал хэвээр байх болно. Орчин үеийн жийп автомашин, сайн чанарын том буутай чинээлэг хүмүүс тал хээрийн бүсэд зугаа цэнгэл хөөн хулгайгаар ан хийх нь шинээр гарч буй аюул заналын нэг юм. Энэ асуудлыг мөн анхаарч үзэх хэрэгтэй.

Санхүүжилт муугаас бөхөн хамгаалагчдын цалин хөлс 2005 оны 6 сараас хойш тавигдаагүй байна. Гэсэн хэдий ч бөхөн хамгаалагчид хувийн болон сумын мэдлийн унаагаар ажлаа үргэлжлүүлэн хяналт хийж байна. Бензиний хүрэлцээ бага тул бөхөн хамгаалагч нар сард 2 удаа эргүүл хийдэг. Мотоцикл, бензин, холбооны хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, дүрэмт хувцас, сурталчилгааны материал дутмагийн улмаас бөхөн хамгаалагч нар хангалттай ажиллаж чадахгүй байна. Бөхөн хамгаалагч нар Монголын унаган байгалийн өвийн нэг бөхөнг хамгаалахад сайн бэлтгэгдэн чин сэтгэлээсээ ажиллаж байгааг дурдах ёстой. Орон нутгийн шийдвэр гаргагч наратай харилцаа холбоогоо цаашид улам хөгжүүлж, дээрх аюул заналыг арилгах хэрэгтэй юм. Тиймээс 2005 онд дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар теслийг үргэлжлүүлэн хийхээр дараах зорилтуудыг тавьж байна. үүнд: 1. Бөхөнгийн менежментийн системийг байгуулах 2. Боловсрол, холбооны чиглэлийг хөгжүүлэх 3. Орон нутгийн удирдлага, хүмүүсийг урамшуулах системийг боловсронгуй болгох; 4. Хуулийн хэрэгжилтийг сайжруулах зэрэг орно.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хийсэн хамгааллын үйл ажиллагааны ололтонд тулгуурлан Том өвсөн тэжээлтэн амьтдын сан Говь-Алтай аймаг дахь бөхөн хамгааллын асуудлыг дэмжин теслийн санхүүжилтийг нэмэгдүүлэхээр болоод байна. Дэлхийн байгаль хамгаалах сангийн Нидерландын хөтөлбөрийн газар теслийн 2 дахь шатыг эхлүүлэхээр ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Том өвсөн тэжээлтэн амьтдын санд санхүүгийн тусламжийг өгөөд байна.

Илүү мэдээлэл авахыг хүсвэл Том өвсөн тэжээлтэн амьтдын сангийн хамгааллын менежер Жоп ван де Власаккертай дараах хаягаар холбогдоно уу. [joep@largeherbivore.org](mailto:joep@largeherbivore.org); [www.largeherbivore.org](http://www.largeherbivore.org)

## Теслийн эргэн тойронд

### Төв Азиid Эко-сүлжээ байгуулагдав

Даян дэлхийн байгаль хамгаалах сан GEF-UNEP-ийн дунд зэрэглэлийн "Төв Азиid Эко-сүлжээ" төсөл дуусах шатандас орж, дэлхийн байгаль хамгаалах сангийн Төв Ази дахь хөтөлбөрийн газар хариуцан ажиллаж байна. Теслийн зорилго нь сансрын зургыг дахин боловсруулсан үр дунд үндэслэн одоо байгаа тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, биологийн төрөл зүйл, нийгэм здийн засгийн хөгжил зэргийн мэдээллийг ашиглан хамгаалалтын бүс, нүүдэллэх коридор, цөм бүсийг нэгтгэсэн экологийн сүлжээг бий болгох юм.



Ирээдүйн тусгай хамгаалалттай газар нутгийн загварын үндэс болох экосүлжээний албан ёсны баталгаажуулалт нь бөхөнгийн эзэмшил нутаг, нүүдлийн замыг хамгаалах сайхан боломжийг бий болгоно. Нилээд хэмжээний газар нутгийг хамарсан Бетбакадаа дахь бөхөнгийн популяцийн үндэсэн эзэмшил нутгийг здийн засгийн хэрэглээнээс эргүүлэн татах нь боломжгүй юм. Өвлийн эзэмшил нутгаас зуны эзэмшил нутаг руу нүүхэд бөхөн их хэмжээний газар нутгийг ашигладаг. Бөхөнгийн популяцийн бүрэн бүтэн байдал нь бэлчээр, ойн менежмент хийх зэрэг аж ахуйн хэрэглээ бүхий байгалийн нөөцтэй өрсөлдөхгүй байгаа юм. Урт хугацаагаар газар нутгийг түрээслэж болох ба харин бөхөнгийн нүүдлийн замыг хааж хашиж болохгүй юм.

Эко сүлжээ теслийн удирдах зөвлөл Алмата хотод 2005 оны 10-р сарын 4-5 нд хуралдаж төслийн гүйцэтгэлийн талаар авч хэлэлцэн дараагийн хагас жилд шинэ, бодитой ажил хийхээр төлөвлөлөө. Илүү мэдээлэл авахыг хүсвэл Дэлхийн байгаль хамгаалах сангийн Төв Азиid хөтөлбөрийн газрын захирал, доктор Ольга Переладоватай холбогдоно уу. [OPereladova@wwf.ru](mailto:OPereladova@wwf.ru)

СПЕЦИАЛЬНЫЙ ПРОЕКТ



### "SOS-Сайга" төсөл Казакстанд хэрэгжиж байна.

"Сеймар нийгмийн сан" Казакстан дахь бөхөнгийн популяцийг хамгаалах зорилготойгоор "SOC-Сайга" экологийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ. Үг төсөл Казахстаны ХАА Яамны Ой, агууруын аж ахуйн хорооны дэргэдэх "Охотзоопром" нэгдэл, Амьтан судлалын хүрээлэнгийн (Шинжлэх ухаан боловсролын яам) дэмжлэгтэйгээр 2005 оны 6 сард эхэлсэн. Теслийн зорилго нь байгалийн нөөц, дархан цаазат газар, байгаль орчны териийн бус байгууллагад тусламж үзүүлэх, бөхөнгийн популяци, түүний нөхөн сэргээлтийг бий болгох, бөхөн хамгаалагч наарт дэмжлэг үзүүлэх явдал юм. Бөхөнгийн популяцийн мониторинг ажиглалтанд үр ашигтай системийг бий болгох, хулгайн анг хянах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх зэрэг зорилтуудыг тавьжээ. "SOC-Сайга" хөтөлбөрийн хүрээнд анхны тэтгэлэг болох байршил тодорхойлогч багаж, зөвхөрийн радио холбоо, сансрын холбооны багаж хэрэгслээр тоноглогдсон УАЗ-10 маркын машинаар ханглаа. "Сэймар нийгмийн сан" сургалт сурталчилгааны олон ажил хийж байна. Олон нийтийн боловсролд зориулсан шинжлэх ухааны хялбаршуулсан кино хийхээр төлөвлөөд байна.

Илүү мэдээлэл авахыг хүсвэл "Саймар нийгмийн сан"-ийн теслийн удирдагч А.Сагингалиеватай холбогдон уу. [Ali\\_sa2002@mail.ru](mailto:Ali_sa2002@mail.ru)

### Баруун хойд Каспийн бөхөнгийн радио-телеметрийн судалгaa

Халимагийн Зэрлэг амьтдын төвөөс нас гүйцсэн 5 бөхөнг радио болон сансрын дамжуулагч хүзүүвчээр хүзүүвчлэн зэрлэг байгальд нь тавих туршилтын теслийг 2004/5 онд хийжээ. Энэ ажлыг Чикагогийн амьтан судлалын нийгэмлэг, Медисоны Их сургуулийн дэмжлэгтэй явуулжээ. Теслийн зорилго нь хашаанд үржүүлсэн амьтад байгалийн нөхцөлд дасан зохицох байдал, тэдгээрийн нүүдлийн хэв маягыг тодорхойлоход оршиж байв. Хүзүүвчтэй амьтад байгалийн зэрлэг сурэгт амжилттай нийлэн орж чадсан. Нэг оонон орооны дараа (ажиглалтаас үзэхэд энэ ооно 17 шаргагчинг хээлтүүлсэн) чононд бариулсан ба бусад 4 бөхөнг үргэлжлүүлэн ажиглаж байна.

**Зураг.** Хүзүүвчлсэн хэржин. Зургыг Нильс Баннефелд

Илүү мэдээлэл авахыг хүсвэл Бүгд найрамдах Халимаг улсын зэрлэг амьтдын төвийн захирал Ю.Ариловтай холбогдоно уу. [kaimsaigak@elista.ru](mailto:kaimsaigak@elista.ru)



Долгион дамжуулагч хүзүүвчтэй бөхөн.  
Гэрэл зураг: Нильс Баннефелд

## Бөхөнгийн талаарх шинэ бүтээлүүд

**Жирнов Л.В., Гунин П.Д., Адъяа Я., Бажа С.Н.** Монголын хуурай бүсийн тууртан амьтдыг хамгаалах стратеги. Редактор О.Шагдарсүрэн. Москва, 2005. Дугаар 45. Хуудас 323.

Энэ номонд Монгол орны зэрлэг тууртан, тухайлбал бөхөнгийн биологи, экологи, хамгааллын судалгааны үр дүнг тусгасан дэлгэрэнгүй хэмжээний мэдээллийг оруулжээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний мэдээлэл, Монголын байгаль орчны тухай хуулийн тухайн шинжилгээг багтаасан. Тууртан амьтдын зөв хэрэглээ, тууртан амьтдыг хамгаалах арга зүйт боловсронгуй болгоход нарийвчилсан мэдээлэл авч болно. Монгол-Оросын хамтарсан Биологийн их бүрэн экспедицтэй холбогдоно уу. [pgunin@online.ru](mailto:pgunin@online.ru)

**Данилкин А.А. Тугалмайтан (Bovidae).** Орос болон зэрэлдээх орны хөхтөн амьтад. Москва, 2005. Хуудас 550.

Нэгэн сэдвэтийн бүтээлд Орос болон хөрш зэрэлдээх орны тугалмайтаны зүйлүүдийн филогени, таксономи, тархац нутгийн хөдлөл зүй, популяцийн хөдлөл зүй, хязгаарлагч хүчин зүйлүүд, байршил газар, идэш тэжээл, үргжил өсөлт, популяцийн бүтэц, хэрэглээ болон хамгааллын талаарх асуудлыг багтаажээ. Бөхөнгийн талаарх бүрэн мэдээллийг энэ номноос авч болно. Шинжилгээний КМК бүтээлийн нийгэмлэгтэй холбогдоно уу. [Kmk2000@online.ru](mailto:Kmk2000@online.ru)

**Неронов В.М., Лущекина А.А., Арылов Ю.Н.** Ижил мөрөн орчмын бөхөнгийн популяцийн нөхөн сэргээлт, хамгаалал дахь экосистемийн хандлага. Ижил мөрний экосистемийн биологийн төрөл зүйл болон биологийн нөөц; өнгөрсөн, одоо, ирээдүй. Олон улсын хурлын эмхтгэл. Саратов, 2005. Хуудас 164-166.

Евроази дахь бөхөнгийн газар зүйн тархац, тоо нягтшилийн түүхэн өөрчлөлтийг анхааран авч үзсэн байна. Элистаад болсон (2002) олон улсын хурлын үеэр боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэсэг болох Ижил мөрний бөхөнгийн нөхөн сэргээлт, хамгаалалд экосистемийн хандлагыг тогтоох санал оржээ. Валерий Неронов, [mab.ru@relcom.ru](mailto:mab.ru@relcom.ru)

**Лущекина А.А., Неронов В.М., Бадмаев В.С., Хлуднев А.В.** Ижил мөрний баруун эргийн хөндийн бөхөнгийн эзэмшил нутгийг хамгаалах төлөвийн тухай өгүүлжээ. Волга мужийн зоологийн сэтгүүл. 2005. Дугаар 1. Хуудас 80-85.

Ижил мөрний эргийн баруун хөндийд бөхөн герөөсийг хамгаалах зорилгоор экологийн сүлжээг бий болгох санал тавыжээ. Байгаль ашиглагч нарт зориулсан санал зөвлөмжүүд багтсан байна. Анна Лущекина, [mab.ru@relcom.ru](mailto:mab.ru@relcom.ru)

**Мелдебеков А.М., Бекенов А.Б., Грачев Ю.А.** Казакстаны бөхөн: одоогийн байдал, судалгааны хэтийн төлөв. Амьтан судлалын хүрээлэнгийн бүтээл (амьтан, экологийн судалгаа). Алматы, 2005. Дугаар 49. Хуудас 176-182.

Казакстан дахь бөхөнгийн популяци, эзэмшил нутгийн 1994-2004 оны хоорондох хөдлөл зүйг өгүүлэлд тусгасан байна. Устюртын бөхөнгийн популяцийн жишээн дээр популяцийн бүтэц, үргжийн чадавхийг тодорхойлжээ. Бөхөнгийн хамгааллыг нэмэгдүүлэхийн тулд байнгын зргүүл хяналтыг бэхжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг ихэсгэх, үргүүлэх, экологийн мониторингийн системийг хөгжүүлэх хэрэгтэй зөвлөж байна. Аманкул Бекенов, [terio@nwrsat.kz](mailto:terio@nwrsat.kz)

**Меджидов Р.А., Каминов Ю.Б., Обгенова О.Б.** Халимагт бөхөнгийн популяцийн бууралт, бөхөн хамгаалах боломжийн тухай орон нутгийнхийн хандлага. //Степной бюллетень, 2005. Дугаар 18. Хуудас 25-28.

Энэ өгүүлэлд орон нутгийнхийн бөхөнд харьцаа, популяцийн доройтлын шалтгааныг тодорхойлох зорилготой нийгмийн судалгааны төвч үр дүнг тусгажээ. Бөхөн хамгаалахтай уялдсан олон нийтийн мэдээлэл сурталчилгааны талаарх мэдээлэл мөн орсон. Судалгааны ажил Черные земли, Яшкул болон Халимагийн Юста дүүрэгт явагдсан. Хамгийн гол аюул занал нь хулгайн ан бөгөөд хулгайн ан гарах шалтгааныг тоймлон гаргажээ. Руслан Меджидов, [centercer@yandex.ru](mailto:centercer@yandex.ru)

**Быкова Е.А., Есипов А.В.** Узбекистаны бөхөнгийн бууралтанд нийгэм-эдийн засгийн нөлөө, бөхөнгийн хамгааллын байдал//Экологийн хамгаалалт, иргэний нийгэм сэтгүүл. 2005. Дугаар 6. Хуудас 31-38.

Узбекистаны бөхөнгийн популяцийн эзэмшил нутагт хийсэн нийгэм-эдийн засгийн судалгааны үр дүнг тусгасан. Судалгааны ажил нь тухайн бүс нутагт хулгайн ангийн түвшинг тодорхойлох, жолооч нарын хулгайн ан хийх сонирхол, орон нутгийн хүмүүсийн хандах хандлага, нөхцөл байдлыг илрүүлэх зорилготой байжээ. Узбекистаны Устюртын сууринд Жаслик тосгоны жишээн дээр хийгдсэн судалгаагаар бөхөнгийн тоо толгойн уналтын гол шалтгаан нь орон нутгийн хүмүүс өнгөрсөн хугацаанд эврийг, одоо махыг ашиглах үүднээс хулгайгаар агнах явдал байна гэж дүгнэжээ. Элена Быкова, [esip@tkt.uz](mailto:esip@tkt.uz)